



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2011 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 228

Улаанбаатар хот

Төсөл хэрэгжүүлэх нэгж байгууллах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Нийслэлд гадаадын зээл, тусламжийн төслүүдийн хэрэгжилтийг зохицуулах журмын 5.1.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


Нэг. Дэлхийн банкны 15 сая ам.долларын хөнгөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Цэвэр агаар” төслийн бэлтгэл ажил, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах үүргийг 2011 оны 2-р сарын 1-ний өдрөөс эхлэн Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь “Төслийг удирдах нэгж”-д хариуцуулсугай.

Хоёр. Төслийн хэрэгжилтэд хяналт тавих, удирдамжаар хангах, хэрэгжилтийг дүгнэх, макро түвшинд болон яам, салбар хоорондын үйл ажиллагааны уялдааг зохицуулах үүрэг бүхий “Цэвэр агаар” төслийг удирдах хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

Гурав. Төслийн бэлтгэл ажлыг богино хугацаанд хийж гүйцэтгэн, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ажиллаж байгаа оролцогч талуудтай бүх талаар хамтран ажиллаж, төслийг амжилттай хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төслийг удирдах хороо (Д.Ганболд)-нд даалгасугай.

Дөрөв. Төслийн бэлтгэл ажлын явцад шаардагдах 1 сая ам.доллар хүртэл хэмжээний урьдчилсан санхүүжилт хийх хөрөнгийн эх үүсвэрийг олж “Зээлийн гэрээ батлагдсаны” дараа урьдчилсан санхүүжилтийн төлбөрийг буцаан авахыг Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Э.Ганхүү)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА,  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ



Г.МӨНХБАЯР

z/y/хороо

111020000858